



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/42/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор Х.Билэгбаяр Утас: 94009818 Цахим хаяг: Bilegbayarkh@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	4
3.1 Ерөнхий зүйл.....	4
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	4
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	5
3.4 Материаллаг байдал	5
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	5
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	6
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	7
3.8 Аудитын гол асуудал	7
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	8
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	8
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	8
4. Аудитын илрүүлэлт	9
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24 № 48

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

07000154

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	52,833,450.07	324,543,263.93
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	9,685,058.39
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	9,685,058.39
3121	Төгрөг	-	9,685,058.39
31211	Төрийн сангийн харилцах	-	9,566,551.39
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	118,507.00
33	АВЛАГА	-	217,670,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	217,670,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	52,833,450.07	97,188,205.54
351	Түүхий эд материал	13,979,721.69	50,634,979.46
35130	Эм боох материал	13,979,721.69	50,634,979.46
354	Хангамжийн материал	38,853,728.38	46,553,226.08
35410	Бичиг хэргийн материал	338,250.00	495,000.00
35420	Аж ахуйн материал	29,510,788.38	30,242,166.08
35440	Түлш, шатах тослох материал	6,565,980.00	7,357,400.00
35460	Хүнсний материал	1,025,210.00	6,001,710.00
35470	Бусад хангамжийн материал	1,413,500.00	2,456,950.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	804,288,199.74	961,547,630.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	804,288,199.74	961,547,630.26
392	Биет хөрөнгө	789,328,199.74	946,587,630.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	644,338,398.95	640,390,798.95
39202	Хуримтлагдсан элэгдэл	(34,127,035.13)	(43,843,913.73)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	70,680,000.00	71,179,484.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(34,830,000.08)	(40,581,623.72)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	205,795,892.30	381,550,516.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(101,326,089.01)	(103,717,874.62)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,915,449.00	39,460,629.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,812,636.33)	(9,953,726.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,050,000.00	15,678,800.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,355,779.96)	(3,575,459.92)
393	Биет бус хөрөнгө	14,960,000.00	14,960,000.00
39301	Програм хангамж	750,000.00	750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(750,000.00)	(750,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	14,960,000.00	14,960,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	857,121,649.81	1,286,090,894.19
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	9,705,508.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	9,705,508.00
413	Өглөг	-	9,705,508.00
4136	Бусад өглөг	-	9,705,508.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	9,705,508.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	857,121,649.81	1,276,385,386.19
51	Засгийн газрын хувь оролцоо	857,121,649.81	1,276,385,386.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	579,657,960.50	579,657,960.50
51101	Өмч: - төрийн	579,657,960.50	579,657,960.50
512	Хуримтлагдсан үр дүн	275,872,270.20	695,136,006.58
51210	Өмнөх үеийн үр дүн	275,872,270.20	275,872,270.20

51220	Тайлант үеийн үр дүн	-	419,263,736.38
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,591,419.11	1,591,419.11
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	857,121,649.81	1,286,090,894.19

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	507,476,478.00	1,369,463,284.41
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	90455208.00	484,322,627.41
120	Нийтлэг татварын бус орлого	90455208.00	484,322,627.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	90455208.00	484,322,627.41
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал	14678058.70	230,584,085.11
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө	75777149.30	253,738,542.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	417021270.00	885140657.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	367514200.00	421997800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	367514200.00	421,997,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9368700.00	435,428,931.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2040200.00	22,023,270.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7328500.00	194,475,661.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	1,260,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого		217,670,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	19000000.00	19500000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19000000.00	19,500,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	21138370.00	8,213,926.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	21138370.00	8,213,926.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	471,662,992.91	949,224,548.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	471,662,992.91	949,224,548.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	468062729.50	916,995,533.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	280641567.43	332,236,156.00
210101	Үндсэн цалин	185362939.19	216846515.00
210102	Нэмэгдэл	74571126.24	74321281.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4527000.00	4640000.00
210104	Урамшуулал	16180502.00	23092422.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	13335938.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35859961.16	44740542.61
210201	Тэтгэврийн даатгал	24595962.33	31460542.61
210202	Тэтгэмжийн даатгал	2815999.60	3320000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2252799.83	2656000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	563199.78	664000.00

Говь-Алтай аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	5631999.62	6640000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17583899.00	18487387.00
210301	Гэрэл, цахилгаан	3248799.00	4178887.00
210302	Түлш, халаалт	13738100.00	14212500.00
210303	Цэвэр, бохир ус	597000.00	96000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21471687.20	43607757.25
210401	Бичиг хэрэг	2047890.00	3451350.00
210402	Тээвэр, шатахуун	16661700.00	26544137.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	867300.00	844800.00
210404	Ном, хэвлэл	35000.00	60000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1408400.00	4080250.00
210408	Бараа материал акталсны зардал	190397.20	8627220.25
2105	Нормативт зардал	26625818.32	356591925.39
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21031178.32	338283925.39
210502	Хоол, хүнс	5594640.00	18308000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	400000.00	2585000.00
210604	Урсгал засвар	400000.00	2585000.00
2107	Томилолт, зочны зардал	642000.00	542000.00
210702	Дотоод албан томилолт	642000.00	542000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19318957.00	2721053.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17558443.00	1629705.00
210807	Газрын төлбөр	8976.00	14960.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	847938.00	418388.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	579600.00	658000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65518839.39	115483711.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4080500.00	6959600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	61438339.39	108524111.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3600263.41	32229015.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	800000.00	32219400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800000.00	32219400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4201.00	9615.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4201.00	9615.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	35813485.09	420,238,736.38
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	350000.00	975,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	975,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-350000.00	(975,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	35463485.09	419,263,736.38

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	579,657,960.50	1,591,419.11	275,872,270.20	857,121,649.81
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	579,657,960.50	1,591,419.11	275,872,270.20	857,121,649.81
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	419,263,736.38	419,263,736.38
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	579,657,960.50	1,591,419.11	695,136,006.58	1,276,385,386.19

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	417,021,270.00	667,470,657.00
13.00	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	417,021,270.00	667,470,657.00
1,310.00	Улсын төвлөрсөн төсвөөс	367,514,200.00	421,997,800.00
131,007.00	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	367,514,200.00	421,997,800.00
1,311.00	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,368,700.00	217,758,931.00
131,101.00	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,040,200.00	22,023,270.00
131,104.00	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,328,500.00	194,475,661.00
131,105.00	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,260,000.00
1,320.00	Орон нутгийн төсвөөс санхүүжих	19,000,000.00	19,500,000.00
132,001.00	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19,000,000.00	19,500,000.00
1,340.00	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	21,138,370.00	8,213,926.00
134,002.00	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	21,138,370.00	8,213,926.00
2.00	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	413,810,270.00	644,765,598.61
21.00	УРСГАЛ ЗАРДАЛ	413,810,270.00	644,765,598.61
210.00	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	410,210,006.59	612,536,583.61
2,101.00	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	280,641,567.43	332,236,156.00
210,101.00	Үндсэн цалин	185,362,939.19	216,846,515.00
210,102.00	Нэмэгдэл	74,571,126.24	74,321,281.00
210,103.00	Унаа хоолны хөнгөлөлт	4,527,000.00	4,640,000.00
210,104.00	Урамшуулал	16,180,502.00	23,092,422.00
210,105.00	Гэрээт ажлын хөлс	-	13,335,938.00
2,102.00	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,859,961.16	44,740,542.61
210,201.00	Тэтгэврийн даатгал	24,595,962.33	31,460,542.61
210,202.00	Тэтгэмжийн даатгал	2,815,999.60	3,320,000.00

Говь-Алтай аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210,203.00	ҮОМШӨ-ний даатгал	2,252,799.83	2,656,000.00
210,204.00	Ажилгүйдлийн даатгал	563,199.78	664,000.00
210,205.00	Эрүүл мэндийн даатгал	5,631,999.62	6,640,000.00
2,103.00	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,445,799.00	20,278,887.00
210,301.00	Гэрэл, цахилгаан	3,248,799.00	4,178,887.00
210,302.00	Түлш, халаалт	14,600,000.00	16,004,000.00
210,303.00	Цэвэр, бохир ус	597,000.00	96,000.00
2,104.00	Хангамж, бараа материалын зардал	22,758,100.00	33,650,300.00
210,401.00	Бичиг хэрэг	2,000,000.00	2,655,500.00
210,402.00	Тээвэр, шатахуун	16,661,700.00	25,317,000.00
210,403.00	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	867,300.00	919,800.00
210,404.00	Ном, хэвлэл	35,000.00	60,000.00
210,405.00	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,047,000.00	600,000.00
210,406.00	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,147,100.00	4,098,000.00
2,105.00	Нормативт зардал	25,549,922.00	166,675,738.00
210,501.00	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,849,922.00	143,112,738.00
210,502.00	Хоол, хүнс	5,700,000.00	20,600,000.00
210,503.00	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	2,963,000.00
2,106.00	Эд хогшил, урсгал засварын зардал	1,427,000.00	3,014,900.00
210,601.00	Багаж, техник, хэрэгсэл	877,000.00	369,900.00
210,604.00	Урсгал засвар	550,000.00	2,645,000.00
2,107.00	Томилолт, зочны зардал	642,000.00	769,057.00
210,702.00	Дотоод албан томилолт	642,000.00	769,057.00
2,108.00	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,772,157.00	3,961,403.00
210,801.00	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,791,243.00	1,992,455.00
210,807.00	Газрын төлбөр	8,976.00	14,960.00
210,808.00	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	847,938.00	418,388.00
210,809.00	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	800,000.00	1,535,600.00
2,109.00	Бараа үйлчилгээний бусад зардал	4,113,500.00	7,209,600.00
210,901.00	Бараа үйлчилгээний бусад зардал	4,113,500.00	7,209,600.00
213.00	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,600,263.41	32,229,015.00
2,132.00	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	32,219,400.00
213,209.00	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	32,219,400.00
2,134.00	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,201.00	9,615.00
213,403.00	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,201.00	9,615.00
3.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3,211,000.00	22,705,058.39
5.00	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,211,000.00	13,020,000.00
22.00	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,211,000.00	13,020,000.00
2,200.00	Дотоод эх үүсвэрээр	3,211,000.00	13,020,000.00

Говь-Алтай аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

225,106.00	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,211,000.00	13,020,000.00
6.00	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(3,211,000.00)	(13,020,000.00)
8.00	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(0.00)	9,685,058.39
10.00	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	9,685,058.39

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	463,247,000.00	440,135,559.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	463,247,000.00	440,135,559.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	462,747,000.00	439,636,159.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	326,400,000.00	307,989,359.00
210101	Үндсэн цалин	202,000,000.00	192,599,718.00
210102	Нэмэгдэл	78,000,000.00	74,321,281.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,000,000.00	4,640,000.00
210104	Урамшуулал	26,000,000.00	23,092,422.00
210105	Гэрээт ажлын хөлс	14,400,000.00	13,335,938.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,334,000.00	41,605,938.61
210201	Тэтгэврийн даатгал	31,054,000.00	28,325,938.61
210202	Тэтгэмжийн даатгал	3,320,000.00	3,320,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,656,000.00	2,656,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	664,000.00	664,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,640,000.00	6,640,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,000,000.00	17,990,385.00
210301	Гэрэл, цахилгаан	3,760,000.00	3,612,385.00
210302	Түлш, халаалт	13,940,000.00	14,282,000.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	96,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,188,100.00	24,514,800.00
210401	Бичиг хэрэг	960,000.00	960,000.00
210402	Тээвэр, шатахуун	21,902,300.00	20,377,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,042,800.00	919,800.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	60,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,583,000.00	1,598,000.00
2105	Нормативт зардал	38,627,200.00	38,590,129.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	28,027,200.00	28,027,129.00
210502	Хоол, хүнс	7,600,000.00	7,600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,000,000.00	2,963,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,977,300.00	3,900,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,477,300.00	2,400,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	460,000.00	290,000.00
210702	Дотоод албан томилолт	460,000.00	290,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,970,000.00	1,968,948.00
210807	Газрын төлбөр	15,000.00	14,960.00

Говь-Алтай аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	419,000.00	418,388.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,536,000.00	1,535,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,790,400.00	2,786,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,790,400.00	2,786,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00	499,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	499,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	499,400.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	463,247,000.00	449,702,111.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	421,997,800.00	421,988,185.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	421,997,800.00	421,988,185.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	19,500,000.00	19,500,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	19,500,000.00	19,500,000.00
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	21,749,200.00	8,213,926.00
122001	Хандив тусламж /дотоод/	21,749,200.00	8,213,926.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	9,566,551.39

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	217,640,424.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	217,640,424.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	185,920,424.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,246,797.00
210101	Үндсэн цалин	24,246,797.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,134,604.00
210201	Тэтгэврийн даатгал	3,134,604.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,288,502.00
210301	Гэрэл, цахилгаан	566,502.00
210302	Түлш, халаалт	1,722,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,135,500.00
210401	Бичиг хэрэг	1,695,500.00
210402	Тээвэр, шатахуун	4,940,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,500,000.00
2105	Нормативт зардал	128,085,609.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	115,085,609.00
210502	Хоол, хүнс	13,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,134,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,989,900.00
210604	Урсгал засвар	1,145,000.00
2107	Томилолт, зочны зардал	479,057.00
210702	Дотоод албан томилолт	479,057.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,992,455.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,992,455.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,423,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,423,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,720,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,720,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,720,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	217,758,931.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	217,758,931.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	22,023,270.00
131104	Дээд шагна төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	194,475,661.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,260,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Билэгбаяр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18 -ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төв нь "Үйлчлүүлэгчдэд ээлтэй, сэтгэлд хүрсэн эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламжийг жигд, хүртээмжтэй хүргэх" байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зарлага 471.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 7.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлын нийт зардал 949.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 18.9 сая төгрөг, 80 хувь буюу 15.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлсон байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 50 хувиар буюу 429.0 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, авлага, өглөг эздийн өмчийн данс байна.

Авлага дансны үлдэгдэл оны эцэст 217.7 сая төгрөгөөр өссөн нь эрүүл мэндийн даатгалаас цар тахалтай холбоотой хэвтэн эмчлүүлэгчдийн санхүүжилтийг дутуу олгосонтой холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 97.2 сая төгрөг болж 44.4 сая төгрөгөөр өссөн нь хандив тусламжаар ирсэн бараа материалтай холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 230.8 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 230.6 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, 8.6 сая төгрөгийн бараа материал акталж, үйл ажиллагаандаа 408.4

сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 97.2 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,164.0 сая төгрөг болж 171.6 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 13.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 254.0 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 34.4 сая төгрөгийн хөрөнгийг данснаас акталж, 1.5 сая төгрөгийг шилжүүлсэнтэй холбоотой байна. Тайлант оны эцэст 1,164.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Үндсэн хөрөнгийн үнэ төлбөргүйгээр хүлээн авсан хөрөнгө нэмэгдсэн нь үлдэх өртгийг нэмэгдүүлэх шалтгаан болсон байна.

Өглөг дансны үлдэгдэл онц эцэст 9.7 сая төгрөгөөр өссөн нь эрүүл мэндийн даатгалаас цар тахалтай холбоотой хэвтэн эмчлүүлэгчдийн санхүүжилтийг дутуу олгосонтой холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,276.4 сая төгрөг болж 419.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 419.3 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 483.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслийг 463.2 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс 20.0 сая төгрөгөөр буурсан нь хөдөө орон нутаг ажилласан тэтгэмжийг аймгийн Эрүүл мэндийн газраас олгохоор болсонтой холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 2 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 463.2 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 449.7 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 440.1 сая төгрөгийг зарцуулж 9.6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 440.1 сая төгрөг буюу 98 хувьтай байгаа нь 9.6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 217.7 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба 217.6 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 0.1 сая төгрөг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, худалдан авалтын И баримтыг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Говь-Алтай аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 562.4 сая төгрөгийн 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн хуудаст ил тод байршуулахаас 499.8 сая төгрөгийн 170 мэдээллийг ил тод бүрэн байршуулсан байна. Горим сорил хэрэгжүүлсний үр дүнд шилэн дансанд байршуулсан, 62.6 сая төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй зөрчилтэй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 10.2 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг дутуу шивүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл

хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.5 сая төгрөгийн төлбөрийн акт, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг биелүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар: Бараа материалын дансны үлдэгдлийг тулган баталгаажуулах, авлагын барагдуулалт, төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 14.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2.4 сая төгрөгийг залруулан, 0.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 11.5 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн үр дүнгийн тайланг 2.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залрууллаа.

4.2 Төлбөрийн акт

- Жолоочийн замын хуудасгүй, анхан шатны баримтгүйгээр 0.2 сая төгрөгийн шатахуун зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.
- Ажиллагсдын илүү цагийн хөлсийг тооцоход 2 ажилтанд 0.3 сая төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2-т "Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан бол үндсэн цалингаас нь тооцон нэмэгдэл хөлс олгоно" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

- Татварын тодорхойлолтоор 0.9 сая төгрөгийн 8 нэр төрлийн татвар зөрүүтэй, газрын төлбөрийн үлдэгдэл 0.04 сая төгрөг нийт 0.94 сая төгрөгийн өглөг, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

- И баримтгүй 10.2 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалттай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- Эмийн хадгалалт хамгаалалтыг сайтар баримтлаагүйгээс 0.4 сая төгрөгийн эм акталсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4.1-т "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах", 72.4.3-т "Агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, хэмжих хэрэгслийн баталгаажилт, урьдах тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авах" гэсэн заалттай нийцэхгүй оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

• 4.4 Зөвлөмж

1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 10 төрлийн худалдан авалтыг мэдээлээгүй зөрчил илэрлээ.

3.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6.4.4-т "Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг" гэсэн заалтыг мөрдөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Цээл сумын ЭМТ	7	14.5	1	2.4	2	0.5	3	11.5	1.0	0.0